



ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД САЛБАР ДУНДЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ

2019.10.03



БАРИМТЛАХ ТУШААЛ, ШИЙДВЭР



1. 2016 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/328

“ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАЖ ЖУРАМ”-ЫН 3 дугаар зүйлийн 3.10 –т Өрх эрүүл мэндийн эмч, багийн эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтны үүрэг тусгагдсан.

2. 2017 оны Хууль зүйн дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/173, А/25, А/380 дугаар тушаал



3.10.1 Үзлэг, шинжилгээ хийх зөвлөгөө өгөх, гэрийн эргэлтийн үед гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүйг таамагласан тохиолдолд нийгмийн нийгмийн ажилтанд мэдээлэх тэмдэглэл хөтлөх баримтжуулах


3.10.2 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлийн гишүүний бие махбодь, сэтгэцийн өөрчлөл, гэмтэлийг эмчлэх, нөхөн сэргээх эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэг, мэргэжлийн эмчид шилжүүлэх, эмчилгээ үйлчилгээний үр дүнг хянах заалтуудын хүрээнд

Түвшинхолбоо ӨЭМТ

Гэрийн эргэлтийн үед хүчирхийлэлд өртсөн нэг гэр бүлийн 4 хохирогчийг багийн нийгмийн ажилтанд мэдээлж Хамгаалах байранд хүргүүлсэн байна.

Аминхолбоо ӨЭМТ

Хамтарсан багийн хурлаар хүчирхийлэлд өртсөн гэх нэг иргэний гомдлын дагуу хуралдаж, хэсгийн цагдаагийн хамгаалалтанд шилжүүлж, сэтгэцийн эмчид хандан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.



МЭДС ТОБ-ӨЭМТ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 2 өрхийн 3 хүүхдийг илрүүлж багийн нийгмийн ажилтан, цагдаад мэдээлж тэмдэглэл хөтөлсөн. Мөн 12 настай охиныг эмэгтэйчүүдийн эмчид үзүүлсэн өөрчлөлт гэмтэлгүй оношлогдсон хэдийч хамтарсан багийн хурлаар хүүхдийг тусгаарлах байранд 10 хоног байршуулсан.

12-р багаас 9-р сургуулийн бага ангийн сурагч Н хичээлдээ тогтвортой сууж чаддаггүй гэсэн байдлыг Хамтарсан багийн хурлаар хуралдаж, сэтгэцийн эмчид үзүүлж зөвлөгөө авсаны дагуу сургуулийн нийгмийн ажилтантай, эцэг эхтэй нь хамтран

✓ Зан үйлийн төлөвшил тогтоох зорилгоор ангийн багш, сургуулийн эмч, эцэг эхийг оролцуулсан зөвлөмж ярилцлага 2 удаа зохион байгуулсан ба уух ёстой эмийг цаг хугацаанд нь уулгаж байгаа эсэхэд гэрийн эргэлтээр тогтмол хяналт тавьж байна.



Госхот ӨЭМТ

Тус багийн Хамтрасан баг 8 дугаар байрны 2 дугаар орцны подволд аав ээж нь хүүхдээ цоожлодог, байнга зоддог гэх дуудлагын дагуу:

- Хөршүүдээс нь мэдээлэл тодруулага авсан
- Сургуулийн нийгмийн ажилтантай уулзаж хүүхдийн зан байдлын талаар тодруулсан
- Хүүхдийн ээжтэй болон хүүхэдтэй уулзаж үзлэг хийж, зөвлөгөө өгсөн
- Хамгаалалтанд авсан байна.

Хамтарсан багийн хурлаар Ш нь өөрийн төрсөн эх болох У-н эрх чөлөөнд халдаж зодож гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн асуудал гарсан ба Нэгдсэн эмнэлэгт үзлэг хийгдэж эмнэлгийн дүгнэлтийн дагуу багийн хэсгийн байцаагч аюулгүйн зэргийн үнэлгээ хийж Зөрчлийн 1918000109 дугаартай хэрэг нээж зөрчил үйлдсэн 30 хоног баривчлуулах арга хэмжээ авсан





3.10.3 Хамтарсан багийн хуралдаанд оролцож, мэргэжлийн үнэлгээ дүгнэлтээ хуваалцах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах

Аминхолбоо ӨЭМТ

13,14,16 багийн Хамтарсан баг дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд

- Гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх
- Бага насны хүүхдээ харгалзах хүнгүйгээр үлдээхгүй байх
- Ахуйн хүрээнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтуудыг баг, ӨЭМТ-үүдээр үйлчилүүлж буй үйлчлүүлэгчид сургалт зохион байгуулсан байна. Сургалтанд-874 иргэн

ГХУС-нэг сарын аяны хүрээнд багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад эргүүл хийж 7 зөрчил илэрүүлсэн ба Цагдаагийн байгууллагад мэдээлсэн байна.



Госхот ӨЭМТ

Хамтарсан багийн гишүүд баг, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй эцэг эхчүүдэд “Хүүхдийг дэлгэцийн донтолтоос сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгааг зохион байгуулж 28 удаа 781 иргэнийг хамруулсан байна. Мөн 2070ш гарын авлага тараасан.

МЭДСТОБ ӨЭМТ

АШУҮИС-ын 110 оюутан, сурагчидад Зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн 12, 15-р багийн иргэдэд 2 удаа тус хуулиар сургалт хийсэн ба 243 иргэн хамрагдсан байна.



3.10.4 Гэр бүлд нь буцаах, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээний үед хүүхдийн эрүүл мэндийн байдалд хяналт үнэлгээ хийх



Хамгаалах байранд ирсэн иргэдийг Асран хамгаалагч болон эцэг эхэд шилжүүлэхэд өрхийн эмч нарт үзүүлэн үзлэг хийгдэж хамгаалах байрны их эмч 4 төрлийн зөвлөмж түгээн ажилладаг. Хамтарсан баг болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч гэрийн эргэлтээр тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

3.10.5 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлсэн эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээ, дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн тухай бүртгэл мэдээллийг нэгтгэж, хамтарсан багийн гишүүд болон дээд шатын байгууллагад тайлагнах

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухай хүснэгтээр


№	Өрхийн эрүүл мэндийн төв	Нийт хүн ам	Багийн харьяалал	Хамгаалах байранд Тус багаас хүчирхийлэлд өртсөн ба эрсдэлтэй иргэдийн тоо	Эрүүл мэндийн байгууллагад хандаж тусламж үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	Сэтгэцийн эмчийн зөвлөгөө авсан иргэдийн тоо	Эмэгтэйчүүдийн эмчид хандсан иргэдийн тоо
1	Түвшинхолбоо	12.120	1.2.3 баг	15	10	1	1
2	Госхот	34573	4.5.6.7.8 баг болон 17.18	32	24	3	3
3	Гэрэлтэй	10.975	9,10 баг	4	2	0	0
4	Мэдстоб	17.238	11. 12. 15	10	3	0	1
5	Аминхолбоо	11.843	13. 14. 16	0	0	0	0
	Нийт-109			61	39	4	5

3.10.5 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлсэн эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээ, дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн тухай бүртгэл мэдээллийг нэгтгэж, хамтарсан багийн гишүүд болон дээд шатын байгууллагад тайлагнах

		Бусад мэдээлэл					
	Байгууллагын нэр	Нарийн мэргэжлийн эмчид хандсан	Лаборторийн тусламж үйлчилгээ	Шүүх эмнэлэг	Рентген	Комьютер томо график	Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн
1	Түвшинхолбоо	10	4	3	2	0	3
2	Госхот	13	2	14	2	1	2
3	Гэрэлтэй	1	0	0	0	1	0
4	Мэдстоб	1	0	1	1	0	0
5	Аминхолбоо	0	0	0	0	0	0
	Нийт -61	25	6	18	5	2	5



3.10.6 Бусад



Хамтрассан багийн гишүүдийн хамрагдсан сургалт 2019 онд Хамтарсан багийг чадвахижуулах зорилгоор “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх нь” сургалтанд хамрагдсан.

Санал

1. Хамтарсан багийн гишүүдийг чадвахижуулах сургалтыг тогтмол зохион байгуулах
2. Хамтарсан багийн хурал, зөвлөгөөнийг тодорхой цаг хугацаатай болгох
3. Хурлын товыг ажил олгогчид мэдэгдэх буюу албан тоотоор хүргүүлэх
4. Хамтарсан багийн үйл ажиллагааг тодорхой тайлагнах хугацаа, хариуцсан эзэнтэй байх

Анхаарал тавьсанд баярлалаа